

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ
ХЯНАЛТЫН СУУРЬ
КОНВЕНЦ




14 дүгээр зүйлийг
хэрэгжүүлэх
Удирдамж



FCTC

WHO FRAMEWORK CONVENTION
ON TOBACCO CONTROL



ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ

14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх удирдамж:

**“Тамхинд донтох, тамхинаас
гарахтай холбоотой эрэлтийг
бууруулах арга хэмжээ”**

Оролцогч талуудын Бага хурлын дөрөвдүгээр (шийдвэр дугаар FCTC/COP4(8))
хуралдаанаар баталсан.

Эх хувилбартай дараах хаягаар танилцана уу:

<https://fctc.who.int/publications/m/item/guidelines-for-implementation-of-article-14>

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ

Оролцогч талуудын Бага хурлаас шийдвэрлэх нь:

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц (ТХСК)-ийн 14 дүгээр зүйл (*Тамхинд донтох, тамхинаас гарахтай холбоотой эрэлтийг бууруулах арга хэмжээ*)-ийг харгалзан,

ДЭМБ-ын ТХСК-ийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийг боловсруулах ажлын хэсэг байгуулах, ажлын хэсэгт ахиц дэвшлийн тайлан, боломжтой бол удирдамжийн төслийг Оролцогч талуудын Бага хурлын дөрөвдүгээр хуралдаанд танилцуулахыг үүрэг болгосон FCTC/COP3(15) шийдвэрийг үндэслэн,

Энэхүү удирдамжийн зорилго нь Оролцогч талуудад ДЭМБ-ын ТХСК-ийн 14 дүгээр зүйлийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд туслахад оршиж байгааг цохон тэмдэглэж,

1. ДЭМБ-ын ТХСК-ийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийг хавсралт ёсоор БАТАЛСУГАЙ;
2. Оролцогч талуудын хэрэгжилтийн тайлан болон олон улсын бусад эх сурвалжаар дамжуулан ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан энэхүү удирдамжтай холбоотой мэдээний сан байгуулахыг конвенцийн Нарийн бичгийн даргын газарт ДААЛГАСУГАЙ.

ХАВСРАЛТ

ДЭМБ-ЫН ТХСК-ИЙН 14 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ

ТАМХИНД ДОНТОХ, ТАМХИНААС ГАРАХТАЙ ХОЛБООТОЙ ЭРЭЛТИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

ТАНИЛЦУУЛГА

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц (ДЭМБ-ын ТХСК-ийн 14 дүгээр зүйлд "Оролцогч талууд шинжлэх ухааны нотолгоо, шилдэг туршлагад тулгуурлан, үндэсний нөхцөл байдал болон тэргүүлэх чиглэлийг харгалзан зохистой, цогц, нэгдсэн удирдамж боловсруулан, түгээж, тамхинаас гарах, тамхинд донтолтыг зохих ёсоор эмчлэх үр дүнтэй арга хэмжээ авна" гэжээ.

Тамхинд донтолтын эмчилгээг өөр өөр хэл, өөр өөр соёл заншилд ялгаатайгаар тодорхойлдог. Үүнд заримдаа нийт хүн амын дунд тамхины хэрэглээг бууруулах арга хэмжээг хамруулдаг боловч ихэнхдээ зөвхөн хувь хүнд үзүүлэх тусламж үйлчилгээг ойлгодог байна. Энэхүү удирдамжид аль алийг нь хамруулсан тул "тамхинаас гарахыг хөхиүлэн дэмжих" ба "тамхинд донтолтын эмчилгээ" гэсэн хоёр нэр томъёог хамт ашигласан болно. Тамхинаас гарахыг хөхиүлэн дэмжих бусад үр дүнтэй арга хэмжээний талаар ДЭМБ-ын ТХСК-ийн бусад зүйл, тэдгээрийг хэрэгжүүлэх удирдамжуудад тодорхой заасан болно.

Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, нийгмийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор эдгээр удирдамжийг ашиглахыг хөхиүлэн дэмжинэ. Оролцогч талууд конвенцийн 2.1 дүгээр зүйлийн дагуу ТХСК, түүний протоколууд болон энэхүү удирдамжид санал болгосноос бусад арга хэмжээг нэмэлтээр хэрэгжүүлэх нь зүйтэй.¹

Зорилт

Энэхүү удирдамж нь ДЭМБ-ын ТХСК-ийн холбогдох зүйл заалт болон Оролцогч талуудын Бага хурлын зорилгод нийцүүлэн, шинжлэх ухааны нотолгоонд тулгуурлан, үндэсний нөхцөл байдал, тэргүүлэх чиглэлийг харгалзан конвенцийн 14 дүгээр зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь Оролцогч талуудад туслах зорилготой болно.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үүднээс удирдамж нь:

- i. Оролцогч талууд тамхинаас гарах оролдлогыг дэмжсэн тогтвортой дэд бүтцийг бий болгох буюу бэхжүүлэх, тамхинаас гарахыг хүсч буй тамхичдад үзүүлэх дэмжлэгийг хүртээмжтэй болгох, Энэхүү дэмжлэгийг тогтвортой санхүүжүүлэх нөөц бүрдүүлэх арга хэмжээ авахыг хөхиүлэн дэмждэг.
- ii. Тамхинаас гарахыг хөхиүлэн дэмжих, тамхинд донтолтын эмчилгээний асуудлыг үндэсний тамхины хяналтын хөтөлбөр болон эрүүл мэндийн тогтолцоонд нэгтгэх үр дүнтэй арга хэмжээг тодорхойлдог.

¹ ДЭМБ-ын ТХСК-ийн вэб сайт (<https://fctc.who.int/>)-аас энэхүү удирдамжид хөндөгдсөн асуудлуудаар нэмэлт мэдээллийн эх сурвалжийг харна уу.

- iii. Оролцогч талуудаас туршлагаа солилцож, хамтран ажиллах замаар тамхинаас гарах, тамхинд донтолтыг эмчлэхэд үзүүлэх дэмжлэгийг бэхжүүлэх арга хэмжээ авахыг хүсдэг.

Нэр томъёоны хэрэглээ

Энэхүү удирдамжид дараах нэр томъёог доорх утгаар хэрэглэсэн болно. Үүнд:

- **“Тамхичин”** гэж ямар нэг тамхин бүтээгдэхүүн хэрэглэж буй хүнийг;
- **“Тамхинд донтох”** гэж тамхийг давтан хэрэглэсний дараа үүсэх зан төрх, танин мэдэхүй, физиологийн багц хямралыг. Энэ үед тамхи хэрэглэхийг тэвчиж үл чадам дур төрж, түүнийг хэрэглэхэд хяналт тавих чадвар алдагдана. Тамхи хэрэглэх нь бусад үйл ажиллагаа, үүрэг хариуцлагаас илүү эрхэм зүйл болж, түүнийг тэсвэрлэх чадвар, хор уршиг нь ихэсч, заримдаа биеийн өлсгөлөн байдал үүсэх боловч тамхийг хэрэглэсээр байх болно.²
- **“Тамхинаас гарах”** гэж бусдын дэмжлэгтэйгээр буюу дэмжлэггүйгээр ямар нэг тамхин бүтээгдэхүүнийг хэрэглэхийг зогсоох үйл явцыг;
- **“Тамхинаас гарахыг дэмжих”** гэж тамхи хэрэглэхийг зогсооход хувь нэмэр болж буй нийт хүн амд чиглэсэн арга хэмжээг (үүнд тамхинд донтолтын эмчилгээ хамаарна);
- **“Тамхинд донтолтын эмчилгээ”** гэж тамхичинд тамхинаас гарахад нь туслах зорилгоор зан үйлийн дэмжлэг, эсхүл эм, эсхүл аль алиныг нь өгөхийг³;
- **“Зан үйлийн дэмжлэг”** гэж хүмүүст тамхи хэрэглэхийг зогсооход нь туслах зорилготой эмээс бусад дэмжлэгийг Үүнд тамхины хэрэглээ, тамхинаас гарах талаар мэдлэг олгох дэмжлэг, зан үйлийг өөрчлөх үр чадвар, стратегийг зааж сургах дэмжлэг хамаарна.
- **“Богино хэмжээний зөвлөгөө”** гэж тамхины хэрэглээг зогсоох талаар бүх тамхичдад ердийн зөвлөгөө, үзлэгийн үеэр өгдөг, хэдхэн минут үргэлжлэх зөвлөгөөг

АНХААРАХ АСУУДАЛ

Тамхины хэрэглээ хамаарал үүсгэх үйлчилгээтэй.^{4,5} Тамхи хэрэглэх, тамхины утаанд өртөх нь эрүүл мэнд, эдийн засаг, орчин, нийгмийн сөрөг үр дагавартай бөгөөд хүмүүст эдгээр сөрөг үр дагавар болон тамхинаас гарахын үр өгөөжийг таниулах шаардлагатай.⁶ Дээрх сөрөг үр дагаврын талаарх мэдлэг нь тамхичдад тамхинаас гарах сэдлийг төрүүлдэг гол хүчин зүйлийн нэг байдаг

² Тодорхойлолтыг дараах эх сурвалжаас авсан болно: *Өвчний олон улсын ангилал, Нэмж засварласан 10 дугаар хэвлэл* (ӨОУА-10). Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2007

³ Энэхүү баримт бичигт заримдаа "тамхинаас гарахад үзүүлэх дэмжлэг" гэсэн нэр томъёог ижил утгаар хэрэглэсэн болно.

⁴ Дараах эх сурвалжаас харна уу: *Өвчний олон улсын ангилал, Нэмж засварласан 10 дугаар хэвлэл* (ӨОУА-10). Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2007

⁵ Донтолт, хамаарал гэсэн нэр томъёог энэхүү удирдамж, ДЭМБ-ын ТХСК-ийн Удиртгал, 4 ба 5 дугаар зүйлд ижил утгаар хэрэглэсэн болно.

⁶ ДЭМБ-ын ТХСК-ийн 12 дугаар зүйлд заасанчлан

тул эдгээрийг олон нийт болон бодлого боловсруулагч нарт бүрэн ойлгуулах нь чухал юм.

Тамхинд донтолтын эмчилгээг тамхины хяналтын бусад арга хэмжээтэй хамт хэрэгжүүлэх нь чухал юм. Тамхинаас гарахыг дэмжих, тамхинд донтолтын эмчилгээ хяналтын нэгдсэн цогц хөтөлбөрийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь тамхины болдог. Тамхичдад тамхинаас гарахад нь дэмжлэг үзүүлж, тамхинд донтолтыг амжилттай эмчлэх нь тамхины хяналтын бусад бодлогыг хүлээн зөвшөөрөх, тэдгээрт үзүүлэх нийгмийн дэмжлэгийг нэмэгдүүлж, тамхины хяналтын бодлогын хэрэгжилтийг бэхжүүлдэг. Тамхинаас гарах, донтолтыг эмчлэх арга хэмжээг ДЭМБ-ын ТХСК-ийн бусад зүйлд тусгасан нийт хүн амд чиглэсэн арга хэмжээтэй хослуулснаар тэдгээрийн үр нөлөөг дээд зэрэгт хүргэх боломжтой

Тамхинаас гарах болон донтолтыг эмчлэх стратеги нь шинжлэх ухааны нотолгоонд тулгуурласан байна. Тамхинд донтолтын эмчилгээ үр дүнтэй бөгөөд үр ашигтай, тиймээс эрүүл мэндийн тогтолцооны үр дүнтэй хөрөнгө оруулалт мөн болохыг баталсан шинжлэх ухааны нотолгоо хангалттай байна.

Эмчилгээ хүртээмжтэй, боломжийн үнэтэй байх ёстой. Тамхинд донтолтын эмчилгээ нь олонд хүртээмжтэй, боломжийн үнэтэй, тамхинаас гарах боломжуудын талаар боловсрол олгох бүрэлдэхүүн хэсэгтэй байх ёстой.⁷

Тамхинаас гарах, донтолтыг эмчлэх үйлчилгээнд бүгдийг хамруулахад анхаарна. Тамхинаас гарах стратеги, тамхинд донтолтын эмчилгээнд нас, хүйс, ёс заншил, шашин шүтлэг, боловсрол, бичиг үсэг тайлагдалт, нийгэм-эдийн засгийн байдал, хөдөлмөрийн чадвар алдалт зэрэг хүчин зүйл болон тамхины хэрэглээ өндөртэй бүлгүүдийн хэрэгцээг харгалзах ёстой. Тамхинаас гарах стратеги нь аль болох бүгдийг хамруулсан, боломжийн хирээр хувь хүний хэрэгцээнд нийцсэн байвал зохино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ амин чухал. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь тамхинаас гарах, донтолтыг эмчлэх хөтөлбөрийн чухал бүрэлдэхүүн хэсэг байна.

Иргэний нийгэмтэй идэвхтэй түншлэл тогтооно. ДЭМБ-ын ТХСК-ийн Удиртгал болон 4.7 дугаар зүйлд заасанчлан иргэний нийгмийн идэвхтэй оролцоо, түншлэл нь эдгээр удирдамжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд амин чухал юм.

Тамхи үйлдвэрлэгчдийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос хамгаална. ДЭМБ-ын ТХСК-ийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх стратеги боловсруулахдаа конвенцийн 5.3 дугаар зүйл, түүнийг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу тамхи үйлдвэрлэгчдийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхол, мөн ашиг сонирхлын бодит болон болзошгүй бусад зөрчлөөс хамгаална.

Туршлага солилцохын үнэ цэнэ. Оролцогч талууд хоорондоо туршлага солилцож, хамтран ажилласнаар эдгээр удирдамжийг хэрэгжүүлэх чадавхаа бэхжүүлэх боломжтой.

Эрүүл мэндийн тогтолцоо гол үүрэгтэй. Тамхинаас гарах, донтолтыг эмчлэх явдлыг хөхиүлэн дэмжихэд эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх нь амин чухал юм.

⁷ Боловсролын талаар нэмэлт удирдамжийг ДЭМБ-ын ТХСК-ийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн төсөл (баримт бичиг FCTC/COP/4/7)-өөс харна уу.

ТАМХИНААС ГАРАХ, ДОНТОЛТЫГ ЭМЧЛЭХ ДЭД БҮТЭЦ ХӨГЖҮҮЛЭХ

Суурь мэдээлэл

Тамхинаас гарахыг дэмжих, тамхинд донтолтын үр дүнтэй эмчилгээ хийхэд дэд бүтцийн зарим элементүүд чухал үүрэгтэй. Энэхүү дэд бүтцийн зарим хэсэг (ж.нь, эрүүл мэндийн анхан шатны тусламж) нь олон улс оронд нэгэнт бүрдсэн байна. Тамхинаас гарахыг дэмжих, тамхинд донтолтын эмчилгээг аль болох хурдан, бага зардлаар хөгжүүлэхийн тулд Оролцогч талууд нэгэнт бэлэн байгаа нөөц, дэд бүтцийг ашиглаж, тамхичдад ядаж богино хэмжээний зөвлөгөө өгдөг болох шаардлагатай. Энэхүү наад захын шаардлагыг хангасны дараа төрөлжсөн мэргэшлийн тусламж зэрэг тамхинд донтолтын эмчилгээний бусад механизмыг ("Тамхинаас гарах дэмжлэгийг үе шаттай хөгжүүлэх нь" хэсгээс харна уу) бүрдүүлэх боломжтой юм.

Шаардлагатай дэд бүтцийг төлөвлөх, бүрдүүлэх эхний шатанд мэргэжлийн нийгэмлэг болон энэ чиглэлээр туршлагатай бусад бүлгүүдийг оролцуулах, ингэхдээ ашиг сонирхлын бодит болон болзошгүй зөрчлөөс хамгаалах шаардлагатай.

Зөвлөмж

Оролцогч талууд үндэсний нөхцөл байдал, тэргүүлэх чиглэлийг харгалзан тамхинаас гарахыг үр дүнтэй дэмжих, тамхины донтолтыг зохих ёсоор эмчлэхэд шаардлагатай дэд бүтэц бий болгох, бэхжүүлэх дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Арга хэмжээ

Үндэсний нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх

Дараах чиглэлээр дүн шинжилгээ хийнэ. Үүнд:

- (1) тухайн улсын тамхины хяналт, нэн ялангуяа тамхичдыг тамхинаас гарахыг дэмжих, эмчилгээ хийлгэх эрэлтийг бий болгох бодлогын хэрэгжилтийн байдал, тэдгээрийн үр нөлөө;
- (2) тамхинаас гарахыг дэмжих, тамхинд донтолтын эмчилгээг хөгжүүлэх бодлого;
- (3) хүн амд үзүүлж буй тамхинд донтолтын эмчилгээ, үйлчилгээ, тэдгээрийн үр нөлөө;
- (4) тамхинаас гарах, донтолтыг эмчлэх үйлчилгээг бэхжүүлэх (хэрэв ийм үйлчилгээ байхгүй бол үйлчилгээ бий болгох)-д зориулсан нөөц, үүнд сургалт явуулах чадавх⁸, эрүүл мэндийн дэд бүтэц, бусад шаардлагатай дэд бүтэц;
- (5) хяналт-шинжилгээний тоо мэдээ ("Хяналт-шинжилгээ, үнэлгээ" хэсгээс харна уу). Энэхүү нөхцөл байдлын дүн шинжилгээг шаардлагатай бол стратеги төлөвлөгөө боловсруулахад ашиглана.

⁸ Сургалттай холбоотой удирдамжийг ДЭМБ-ын ТХСК-ийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн төсөл (баримт бичиг FCTC/COP/4/7)-өөс харна уу.

Үндэсний зохицуулалтын механизм бүрдүүлэх буюу бэхжүүлэх

Тамхинаас гарахыг дэмжих, донтолтыг эмчлэх хөтөлбөр боловсруулах буюу бэхжүүлэх үйл ажиллагааг үндэсний зохицуулалтын механизм буюу хариуцсан албан тушаалтан зохицуулна.

Тамхинаас гарах үйлчилгээ, ийм үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий үйлчилгээ үзүүлэгчдийн мэдээний сан байгуулж, тогтмол шинэчилж, хүртээмжтэй болгоно.

Цогц удирдамж боловсруулж, түгээх

Оролцогч талууд шинжлэх ухааны нотолгоо, шилдэг туршлагад тулгуурлан, үндэсний нөхцөл байдал болон тэргүүлэх чиглэлийг харгалзан тамхинд донтолтын эмчилгээний цогц удирдамж боловсруулан, түгээнэ. Удирдамж нь дараах хоёр томоохон бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

- (1) тамхинаас гарахыг дэмжих, тамхинд донтолтын эмчилгээг хүртээмжтэй болгох зорилготой, бодлого, хөтөлбөрийг санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч нарт чиглэсэн **тамхинаас гарахыг дэмжих үндэсний стратеги**;
- (2) тамхичдад тамхинаас гарахад нь дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтнүүдэд зориулсан **эмчилгээний удирдамж**.⁹

Тамхинаас гарахыг дэмжих үндэсний стратеги, эмчилгээний удирдамж нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Нотолгоонд тулгуурласан байна;
- Эдгээрийг боловсруулах явцад ашиг сонирхлын бодит болон боломжит зөрчлөөс хамгаална.
- Эдгээрийг боловсруулахдаа тухайн чиглэлээр туршлагатай эрүүл мэндийн эрдэмтэд, эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, сургагч багш нар, залуучуудтай ажиллагсад, төрийн бус байгууллагууд зэрэг гол сонирхогч талуудтай хамтран ажиллана.
- Эдгээрийг засгийн газрын дэмжлэгтэйгээр буюу удирдлага дор, бусад сонирхогч талуудтай зөвшилцөж, хамтран ажиллах замаар боловсруулна. Гэхдээ эмчилгээний удирдамж боловсруулах ажлыг бусад байгууллага санаачилбал засгийн газартай нягт хамтран ажиллах шаардлагатай.
- Стратеги, удирдамжийг хэрэгжүүлэх, түгээх төлөвлөгөөг хамт боловсруулж, (эрүүл мэндийн болон эрүүл мэндийн бус) үйлчилгээ үзүүлэгчид тамхи хэрэглэхгүй байж үлгэр дуурайлал болохын чухлыг цохон тэмдэглэж, шинжлэх ухааны нотолгоог харгалзан ДЭМБ-ын ТХСК-ийн 5.1 дүгээр зүйлд заасан үүргийн дагуу тогтмол тоймлон үнэлж, цаг үеийн шаардлагад нийцүүлнэ.

Эмчилгээний удирдамжид тавих бусад шаардлага:

- Удирдамжийг эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага, нийгэмлэг зэрэг нь үндэсний хэмжээнд өргөнөөр хүлээн зөвшөөрсөн байна.
- Удирдамжид аль болох өргөн хүрээний арга хэмжээг тусгасан байна, үүнд: тамхичдыг системтэй тодорхойлох, богино хэмжээний зөвлөгөө өгөх, утсаар зөвлөгөө өгөх, тусгайлан сургагдсан мэргэжилтнүүд

⁹ Эмчилгээний удирдамж гэж тамхинд донтолтын эмчилгээний талаар шийдвэр гаргахад нь үйлчилгээ үзүүлэгчид, менежер, өвчтөнүүдэд тус дөхөм болох зорилгоор системтэйгээр боловсруулсан зааварчилгаа юм.

ганцаарчилсан байдлаар зан үйлийн дэмжлэг үзүүлэх, эмийг үнэгүй буюу боломжийн үнээр хүргэх тогтолцоо бүрдүүлэх, тамхины хэрэглээний талаар бүх эмч үзлэгийн явцад тодруулж, тэмдэглэгээ хийхээс эхлүүлээд тамхинаас гарахад дэмжлэг үзүүлэх бүх үе шатыг дэмжсэн тогтолцоо бүрдүүлэх;

- Эрүүл мэндийн болон бусад салбарт үзүүлэх тусламж үйлчилгээг бүхэлд нь хамарсан байна.

Тамхинаас гарахыг дэмжихэд оролцож буй эрүүл мэндийн болон бусад ажиллагсад тамхины хэрэглээнд анхаарах

Эрүүл мэндийн ажиллагсад дараах шалтгааны улмаас тамхи хэрэглэхээс татгалзах нь зүйтэй. Үүнд:

- Тэд үлгэр дуурайлал болдог ба тамхи хэрэглэснээр тамхины эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн тухай эрүүл мэндийн мессежийг үнэгүйдүүлдэг.
- Тамхины хэрэглээг хэвийн гэж үзэх нийгмийн хандлагыг халах нь чухал бөгөөд үүнд эрүүл мэндийн ажиллагсад үлгэр жишээ тогтоох үүрэг хүлээдэг.

Ийм ч учраас тамхинаас гарах, тамхинд донтолтын эмчилгээнд хамрагдахыг дэмжих тусгайлсан хөтөлбөрийг эрүүл мэндийн ажиллагсад болон тамхичдад тамхинаас гарахад нь тусалдаг бусад бүлгүүдийн дунд хэрэгжүүлэх шаардлагатай.

Сургалт явуулах чадавх бүрдүүлэх¹⁰

Ихэнх улсад тамхинаас гарахыг дэмжих, тамхинаас гарахыг хүсэгчдэд дэмжлэг үзүүлэхэд эрүүл мэндийн тогтолцоо¹¹ болон эрүүл мэндийн ажилтнууд гол үүрэгтэй байна. Үүний зэрэгцээ бусад бүлгүүдийг татан оролцуулах нь зүйтэй.

Бүх эрүүл мэндийн ажиллагсад үйлчлүүлэгчдээс тамхины хэрэглээний талаар тодруулж баримтжуулах, богино хэмжээний зөвлөгөө өгөх, тамхинаас гарахыг хөхиүлэн дэмжих, шаардлагатай бол тамхичдыг тамхинд донтолтын тусгайлсан эмчилгээ үйлчилгээнд шилжүүлэх талаар сургагдсан байна.

Богино хэмжээний зөвлөгөө өгөх, тамхинаас гарахыг хөхиүлэн дэмжих, шаардлагатай бол тамхичдыг тамхинд донтолтын тусгайлсан эмчилгээ үйлчилгээнд шилжүүлэх талаар эрүүл мэндийн бус салбарын хүмүүсийг сургаж, тамхинаас гарах, донтолтыг эмчлэх үйл ажиллагаанд татан оролцуулж болно.

Эрүүл мэндийн ажиллагсад болон мэргэжлийн тусгайлсан дэмжлэг ("Тамхичдад тамхинаас гарахад нь туслах тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсэг" гэсэн хэсгээс харна уу) үзүүлэх эрүүл мэндийн бус ажилтнуудыг шаардлагын өндөр түвшинд сургаж бэлтгэх ба тасралтгүй сургалтад хамруулна.

Тамхины хяналт, тамхинаас гарах асуудлыг эрүүл мэндийн болон бусад холбогдох мэргэжилтнүүдийн дипломын өмнөх ба дараах, мөн мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрт тусгана. Сургалтын агуулгад тамхины хэрэглээ, түүний хор уршиг, тамхинаас гарахын үр өгөөж, тамхинаас гарахыг хөхиүлэн дэмжихэд сургагдсан боловсон хүчний гүйцэтгэх үүргийн талаар тусгана.

Эрх бүхий байгууллагууд үндэсний хэмжээнд сургалтын стандартыг тогтооно.

¹⁰ Сургалттай холбоотой удирдамжийг ДЭМБ-ын ТХСК-ийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн төсөл (баримт бичиг FCTC/COP/4/7)-өөс харна уу.

¹¹ Үүнд төрийн байгууллага, улсын ба хувийн эрүүл мэндийн байгууллага, санхүүжүүлэгчид хамаарна.

Тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгоход байгаа нөөц, тогтолцоог ашиглах

Оролцогч талууд бүх тамхичдыг илрүүлж, ядаж богино хэмжээний зөвлөгөө өгөх боломжийг бүрдүүлэхэд эрүүл мэндийн болон бусад салбарт байгаа дэд бүтцийг ашиглана.

Оролцогч талууд байгаа дэд бүтцээ ашиглан тамхинаас гарахыг хүсч байгаа хүмүүсийг тамхинд донтолын эмчилгээнд хамруулна. Уг эмчилгээг хүртээмжтэй, нотолгоонд тулгуурласан, боломжийн үнэтэй байлгана.

Оролцогч талууд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, сүрьеэ, ХДХВ/ДОХ-ын эсрэг эмчилгээ болон бусад нэгэнт тогтсон дэд бүтцийг ашиглан тамхичдад тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох боломжийг эрэлхийлэх нь зүйтэй.

Эрүүл мэндийн бүртгэлд тамхины хэрэглээний талаар заавал тэмдэглэх

Оролцогч талууд үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн бүх бүртгэлд тамхины хэрэглээний талаар заавал тэмдэглэх шаардлага тавьж, нас баралтын гэрчилгээнд тамхины хэрэглээний талаар тэмдэглэгээ хийхийг хөхиүлэн дэмжинэ.

Хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих

ДЭМБ-ын ТХСК-ийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх талаар шуурхай ахиц дэвшил гаргахын тулд энэхүү удирдамжийн үзэл санаанд нийцүүлэн төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах нь амин чухал юм.

Тамхинаас гарахад дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх

Тамхинаас гарахыг дэмжих, тамхинд донтолын эмчилгээ хийх үндэсний дэд бүтэц бий болгох буюу бэхжүүлэхэд санхүүгийн болон техникийн нөөц шаардагдах тул ДЭМБ-ын ТХСК-ийн 26 дугаар зүйлд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох нь амин чухал юм.

Оролцогч талууд улсын төсөвт учруулах дарамтыг бууруулахын тулд тамхинаас гарахад үзүүлэх дэмжлэгтэй холбоотой зардлыг тамхи үйлдвэрлэгч, борлуулагч нарт үүрүүлэх боломжийг эрэлхийлнэ. Үүний тулд тамхины тусгайлсан татвар, тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрлийн хураамж, тамхин бүтээгдэхүүний бүртгэлийн хураамж, тамхины дистрибьютер болон жижиглэн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хураамж, тамхи үйлдвэрлэгч болон борлуулагч нарт хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд ногдуулах мөнгөн торгууль, тамхи үйлдвэрлэгч болон борлуулагч нараас жил бүр авах тамхины тандалт/хяналтын хураамж зэргийг хуульд нийцүүлэн бий болгож ашиглах боломжтой Үүнээс гадна тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг бууруулах арга хэмжээг (ДЭМБ-ын ТХСК-ийн 15 дугаар зүйлд заасанчлан) амжилттай хэрэгжүүлснээр улсын төсвийн орлогыг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх боломжтой.

ТАМХИЧДАД ТАМХИНААС ГАРАХАД НЬ ТУСЛАХ ТОГТОЛЦООНЫ ҮНДСЭН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

Суурь мэдээлэл

Өмнөх хэсэгт өгүүлсэнчлэн тамхичдад олон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нар тусламж үзүүлэх боломжтой бөгөөд энэ нь богино хэмжээний зөвлөгөө,

утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээ¹² зэрэг нийт хүн амд чиглэсэн ерөнхий үйлчилгээнээс гадна зан үйлийн дэмжлэг, эмийн эмчилгээ зэрэг тусгайлан сургагдсан мэргэжилтнүүд зарим тохиолдолд төлбөртэйгөөр үзүүлдэг мэргэжлийн тусгайлан үйлчилгээ хэлбэртэй байна. Зан үйлийн дэмжлэг болон эмийн эмчилгээ нь дангаараа буюу хослуулсан тохиолдолд үр дүнтэй, үр ашигтай бөгөөд хослуулсан үед илүү үр дүнтэй болохыг харуулсан шинжлэх ухааны нотолгоо нэлээд байна.

Зөвлөмж

Оролцогч талууд эрүүл мэндийн болон бусад салбарт тамхинаас гарахад дэмжлэг үзүүлэх, донтолтыг эмчлэх тогтолцоо бүрдүүлэхдээ Үндэсний нөхцөл байдал, тэргүүлэх чиглэлийг харгалзах бөгөөд дор тайлбарласан бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан байна.

Оролцогч талууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нар бүгд тамхинаас гарахад дэмжлэг үзүүлдэг байхад анхаарна. Үүнээс гадна Оролцогч талууд эрүүл мэндийн бус салбарт, тусгайлан сургагдсан эрүүл мэндийн бус үйлчилгээ үзүүлэгчдээр тамхинаас гарахад дэмжлэг үзүүлэх, эмчилгээ хийлгэх боломжийг судалж, нэн ялангуяа зарим бүлгийн тамхичдад эрүүл мэндийн бус салбарт үйлчилгээ үзүүлэх нь илүү үр дүнтэй болохыг¹³ харуулсан шинжлэх ухааны нотолгоо байвал энэ чиглэлээр арга хэмжээ авна.

Арга хэмжээ

Нийт хүн амд чиглэсэн ерөнхий үйлчилгээ

Олон нийтийн сургалт, сурталчилгаа. Олон нийтийн сургалт, сурталчилгаа нь тамхинаас гарахыг хөхиүлэн дэмжих, үүнд дэмжлэг үзүүлэх, тамхичдад энэхүү дэмжлэгийг авах сэдэл төрүүлэхэд чухал ач холбогдолтой юм.¹⁴ Үүнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр төлбөртэй болон үнэгүй зар сурталчилгаа явуулах үйл ажиллагаа хамаарна.

Богино хэмжээний зөвлөгөө. Богино хэмжээний зөвлөгөө өгөх үйлчилгээг эрүүл мэндийн тогтолцооны бүхий л түвшинд үзүүлнэ. Эрүүл мэндийн бүх ажиллагсад үйлчлүүлэгчээс тамхины хэрэглээний талаар асууж, эрүүл мэндийн бүртгэлд нь тэмдэглэж, тамхинаас гарах талаар богино хэмжээний зөвлөгөө өгч, зохих эмчилгээ хийлгэхээр шилжүүлэх талаар сургагдсан байна. Богино Хэмжээний зөвлөгөө нь тусламж үйлчилгээний стандартын бүрэлдэхүүн хэсэг байх ба түүний хэрэгжилтэд тогтмол хяналт- шинжилгээ хийнэ.

Утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээ. Оролцогч талууд утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх ба зөвлөгөөг тусгайлан сургагдсан мэргэжилтнүүд өгнө. Утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг өргөнөөр сурталчилж, хангалттай тооны боловсон хүчнээр хангаж, тамхичдад хүссэн үедээ өөрт тохирсон зөвлөгөө авах боломжийг бүрдүүлнэ. Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүний сав, баглаа, боодол дээр зөвлөгөө өгөх утасны дугаарыг оруулах нь зүйтэй.

¹² Утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээ гэдэг нь хүсэлтийн дагуу буюу үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээ юм. Хүсэлтийн дагуу зөвлөгөө өгнө гэдэг нь зөвлөгөө авахаар утасдсан тамхичинд шуурхай зөвлөгөө өгөх үйлчилгээ байдаг бол үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар зөвлөгөө өгөхдөө урьдчилан гаргасан графикайн дагуу тамхичид руу утасдаж зөвлөгөө өгөх үйлчилгээ юм.

¹³ Тухайлбал, залуучууд, эцэг эхчүүд, ядуу эмзэг бүлгийн хүн ам.

¹⁴ ДЭМБ-ын ТХСК-ийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн төсөл (баримт бичиг FCTC/COP/4/7)-ийг харна уу.

Мэргэжлийн тусгайлсан үйлчилгээ

Тамхинд донтолтын эмчилгээ. Тамхинаас гарах дэмжлэг шаардлагатай тамхичдыг боломжтой бол тусгайлан сургагдсан мэргэжилтнүүдийн үзүүлэх мэргэжлийн үйлчилгээнд хамруулна. Энэхүү үйлчилгээ нь зан үйлийн дэмжлэг, шаардлагатай бол эмийн эмчилгээнээс бүрддэг. Үйлчилгээг эмч, сувилагч, эх баригч, эм зүйч, сэтгэлзүйч зэрэг эрүүл мэндийн болон бусад сургагдсан мэргэжилтнүүд үзүүлж болно. Үйлчилгээг тамхичдад хүртээмжтэй байлгаж, аль болох үнэгүй буюу боломжийн үнээр үзүүлнэ. Мэргэжлийн тусгайлсан үйлчилгээ нь үндэсний буюу бусад холбогдох стандартын шаардлагыг хангасан байна.

Эмийг хүртээмжтэй болгох

Тамхинаас гарах магадлалыг нэмэгдүүлдэг болох нь шинжлэх ухааны нотолгоогоор батлагдсан эмийг тамхинаас гарахыг хүсч буй тамхичдад хүртээмжтэй болгож, аль болох үнэгүй буюу боломжийн үнээр өгөх арга хэмжээ авна.

Хууль тогтоомжийн хүрээнд зарим эмийг нийт хүн амд хүртээмжтэй болгож болно. Зарим улсын туршлагаас харахад зарим эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь тамхинаас гарах оролдлогын тоог нэмэгдүүлдэг байна.

Засгийн газрууд хамтарч эсхүл бүс нутгийн эдийн засгийн байгууллагуудаар дамжуулж нэгдсэн худалдан авалт хийснээр эмийн үнийг бууруулж, тамхинаас гарах эмчилгээ тамхичдад үнийн дарамт үзүүлэхээс сэргийлэх арга хэмжээ авна. Өртөг багатай, үр дүнтэй эм¹⁵ байгаа тохиолдолд түүнийг стандарт эмчилгээнд ашиглана.

Шинэ нотолгоо, шинэлэг арга, мэдээллийн хэрэгслийг ашиглах

Оролцогч талууд тамхинаас гарах, донтолтыг эмчлэх талаар шинээр гарч буй шинжлэх ухааны нотолгоо, шинэ аргуудыг анхааралдаа байлгах арга хэмжээ авна.

Оролцогч талууд тамхинаас гарах, донтолтыг эмчлэх шинэ аргуудад нээлттэй байхын зэрэгцээ шинжлэх ухааны нотолгоонд тулгуурлан тэдгээрийг эрэмбэлнэ.

Зарим орны туршлага, нотолгооноос харахад Үндэсний тамхигүй өдрийг (зарим тохиолдолд Дэлхийн тамхигүй өдөртэй хамтатган) зохион байгуулах нь тамхичдад тамхинаас гарах сэдэл төрүүлэх үр дүнтэй, зардал багатай арга болдог. Гар утас, интернэтийн хэрэглээ өндөртэй улс орнуудад гар утсаар мессеж илгээх, интернэтэд суурилсан зан үйлийн дэмжлэг үзүүлэх нь үр дүнтэй байж болдог. Эдгээр болон бусад аргуудыг тусламж үйлчилгээний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болгон үзүүлэхийг зөвлөмж болгоход хангалттай нотолгоо одоогоор байхгүй хэдий ч үр дүнг нь судалж байна. Олон улс оронд радио нь хэвлэл мэдээллийн хамгийн түгээмэл, зардал багатай хэрэгсэл байдаг тул тамхинаас гарах мессеж, зөвлөгөөг хүргэхэд радиог ашиглах боломжийг судлах нь зүйтэй. Зарим оронд орон нутгийн сайн дурын уран сайханчид олон нийтэд хүрэх чухал суваг хэвээр байгаа тул тамхинаас гарах тусламж үйлчилгээний тухай мэдээллийг түгээхэд энэхүү сувгийг ёс заншилд нийцсэн бусад аргуудын хамтаар ашиглах боломжтой юм.

¹⁵ Шинжлэх ухааны нотолгоогоор баталгаажсан байна ("Хяналт-шинжилгээ, үнэлгээ" хэсгээс харна уу)

ТАМХИНААС ГАРАХ ДЭМЖЛЭГИЙГ ҮЕ ШАТТАЙ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Суурь мэдээлэл

ДЭМБ-ын ТХСК-ийн бусад зүйлд¹⁶ дурдсан тамхины эрэлтийг бууруулах тамхины хяналтын бодлого нь тамхинаас гарахыг хөхиүлэн дэмжих дэмжлэгт орчин бүрдүүлэхэд анхаардаг. Тамхинаас гарахыг дэмжих, донтолтыг эмчлэх арга хэмжээг эдгээр бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх нь хам үйлчилгээ үзүүлж, нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх үр нөлөөг дээд түвшинд хүргэнэ.

Тамхичдын дотор тамхинаас гарахыг хүсч байгаа хүмүүсийн эзлэх хувь бага байсан ч гэсэн нийт тамхичдын тоо их бол тамхинаас гарахад үзүүлэх дэмжлэг авах эрэлт хэрэгцээ их байж болно.

Оролцогч талуудын нөхцөл байдал, тэргүүлэх чиглэлээс хамаарч тамхинаас гарах, донтолтыг эмчлэх тусламж үйлчилгээний нэгдсэн цогц тогтолцоог нэг дор эсхүл үе шаттайгаар бүрдүүлж болно. Зарим Оролцогч талууд ийм нэгдсэн тогтолцоо нэгэнт бүрдүүлж чадсан бөгөөд бүх Оролцогч талууд тамхинаас гарах, донтолтыг эмчлэх аль болох өргөн хүрээний арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зорих шаардлагатай.

Нөөц голдуу хязгаарлагдмал байдаг тул энд тамхинд донтолтын эмчилгээг хэрхэн үе шаттай хөгжүүлэх талаар толилуулсан болно.

Зөвлөмж

Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн бусад зүйлд¹⁷ заасан тамхинаас гарах, донтолтыг эмчлэх тусламж үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

Оролцогч талууд эрүүл мэндийн болон бусад салбарт байгаа дэд бүтцийг ашиглан бүх тамхичдыг илрүүлж, ядаж богино хэмжээний зөвлөгөө өгөх арга хэмжээ авна.

Оролцогч талууд үндэсний нөхцөл байдал болон тэргүүлэх чиглэлийг харгалзан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Арга хэмжээ

Суурь дэд бүтэц бүрдүүлж, тамхинаас гарах оролдлогыг хөхиүлэн дэмжих орчин бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ

Тогтолцооны бүрэлдэхүүн хэсгийг байгуулах

- Хүн амыг тамхин бүтээгдэхүүний хор хөнөөлийн талаар сайн мэдээлэлтэй болгох;
- Үндэсний тамхины хяналтын төлөвлөгөөний хэсэг болсон тамхинаас гарах, донтолтыг эмчлэх асуудлаар үндэсний зохицуулалтыг бий болгон, бэхжүүлж, санхүүжүүлэх;
- Тамхинаас гарахыг дэмжих үндэсний стратеги, тамхинд донтолтын эмчилгээний удирдамж боловсруулж, түгээх;

¹⁶ Тухайлбал 6, 8, 11, 12, 13 дугаар зүйл

¹⁷ Тухайлбал 6, 8, 11, 12, 13 дугаар зүйл

- Тамхинаас гарах, донтолтыг эмчлэх хөтөлбөрийг тогтвортой санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхойлж, хөрөнгө хуваарилах;
- Боломжтой бол тамхинд донтолтыг өвчин буюу эмгэг хэмээн тооцож, эмчилгээний зардлыг нь эрүүл мэндийн даатгал буюу эрүүл мэндийн санхүүжилтийн бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх.

Эрүүл мэндийн ажиллагсдын дунд асуудлыг шийдвэрлэх

- Тамхинд донтох, тамхинаас гарахтай холбоотой асуудлыг анагаахын, нүүр ам судлалын, сувилахуйн, эм зүйн болон бусад холбогдох дипломын өмнөх болон дараах сургалтын цөм хөтөлбөр, мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөр, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын асуулт зэрэгт тусгах;
- Богино хэмжээний зөвлөгөө өгөх талаар эрүүл мэндийн ажиллагсдыг сургах;
- Шаардлагатай бол эрүүл мэндийн бус салбарын ажиллагсдыг тамхинаас гарахад дэмжлэг үзүүлэх, донтолтыг эмчлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах;
- Тамхи хэрэглэдэг эрүүл мэндийн ажиллагсад болон бусад үйлчилгээ үзүүлэгч нарын дунд тамхинаас гарахыг хөхиүлэн дэмжиж, шаардлагатай бол тамхинаас гарахад нь дэмжлэг үзүүлэх.

Богино хэмжээний зөвлөгөөг эрүүл мэндийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгон нэгтгэх

- Тусламж үйлчилгээний бүхий л шатлалд үйлчлүүлэгчийн тамхины хэрэглээний талаарх мэдээллийг эрүүл мэндийн болон бусад бүртгэлд тэмдэглэн баримтжуулдаг болох;
- Богино хэмжээний зөвлөгөөг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний багцад нэгтгэх;
- Эрүүл мэндийн тогтолцооны бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг богино хэмжээний зөвлөгөө өгдөг болгох;
- Боломж, шаардлага байгаа бол эрүүл мэндийн бус салбарт богино хэмжээний зөвлөгөө өгдөг болох;
- Шаардлагатай бол тамхинаас гарах зөвлөгөө өгөхөд зарцуулсан цаг болон эмийн зардлыг эрүүл мэндийн ажиллагсдад нөхөн олгодог байх.

Тамхинаас гарах оролдлого амжилттай болох магадлалыг нэмэгдүүлдэг арга хэмжээ

Тамхинаас гарах дэмжлэг үзүүлэх, донтолтыг эмчлэх чадавх бүрдүүлэх

- Тамхинд донтолтын эмчилгээнд хамрагдах боломжийн талаар хүн амд мэдээлэл хүргэж, эмчилгээнд хамрагдахыг хөхиүлэн дэмжих;
- Тамхинаас хэрхэн гарах талаар үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар утсаар үнэгүй зөвлөгөө өгдөг үйлчилгээ бий болгох. Хэрэв нөөц хязгаарлагдмал бол хүсэлтийн дагуу утсаар зөвлөгөө өгдөг үйлчилгээ бий болгох;
- Үр дүнтэй эмийг үнэгүй буюу боломжийн үнээр хүртээмжтэй болгох;
- Тусламж үйлчилгээний стандартад нийцсэн тамхинд донтолтын эмчилгээний сүлжээ байгуулах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ БА ҮНЭЛГЭЭ

Суурь мэдээлэл

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь мэдээ цуглуулж, өөрчлөлт гарсан эсэхийг баримтжуулах замаар тодорхой арга хэмжээ буюу хөтөлбөрийн үр нөлөө, ахиц дэвшлийг хэмждэг. Аливаа арга хэмжээ, хөтөлбөрийг үе үе тоймлон үнэлэх шаардлагатай. Шинжлэх ухааны нотолгоо гэдэг нь албан ёсны судалгааны ажил гүйцэтгэх замаар бүрдүүлсэн нотолгоо бөгөөд үүнд мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд бүрдүүлсэн нотолгоо хамаардаг.¹⁸

Эмчилгээний үр дүнтэй арга боловсруулж, тамхичдад хамгийн оновчтой аргаар хүргэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ амин чухал юм. Үндэсний түвшинд хяналт-шинжилгээ, үнэлгээ нь ахиц дэвшлийг хэмжих, шаардлагатай бол арга хэмжээг өөрчлөх, сайжруулах, хязгаарлагдмал нөөцийг хамгийн үр ашигтайгаар ашиглах боломжийг олгодог. Олон улсын түвшинд туршлага солилцоноор Оролцогч талууд өөрсдийн стратегийг сайжруулах боломжтой болдог.

Үндэсний болон олон улсын мэдээллийн системийг ашиглан Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилгоор мэдээ цуглуулах үйл ажиллагааг удирдан чиглүүлж, дэмжих боломжтой.

Зөвлөмж

Оролцогч талууд тамхинаас гарахад дэмжлэг үзүүлэх, донтолтыг эмчлэх стратеги, хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, явцын болон үр дүнгийн үзүүлэлтийн хандлагыг хянана. ДЭМБ-ын ТХСК-ийн 20, 21, 22 дугаар зүйлд заасанчлан мэдээлэл солилцох замаар бусад орны туршлагаас суралцах шаардлагатай.

Арга хэмжээ

Хэмжиж болохуйц зорилтуудыг дэвшүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг тодорхойлж, зорилт тус бүрийн хүрээнд гарч буй ахиц дэвшлийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлно.

Үндэсний нөхцөл байдал болон тэргүүлэх чиглэлийг харгалзан эрүүл мэндийн болон бусад тусламж үйлчилгээ үзүүлэгчдийг өөрсдийн гүйцэтгэлийг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд оролцохыг хөхиүлэн дэмжинэ.

Үр ашигтай, хэрэглэхэд хялбар, аргазүйн үндэслэл сайтай, Орон нутгийн нөхцөл байдалд тохирсон мэдээ цуглуулах системийг ашиглана.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Суурь мэдээлэл

ДЭМБ-ын ТХСК-ийн 22 дугаар зүйлд заасанчлан Оролцогч талууд олон улсын хамтын ажиллагаа хөгжүүлэх үүрэг хүлээдэг. Тамхинаас гарахад дэмжлэг үзүүлэх, донтолтыг эмчлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь конвенцийн хэрэгжилтийг дэмжих, бэхжүүлэх бас нэгэн арга зам юм.

¹⁸ Судалгаанд тулгуурласан нотолгооны тодорхойлолтыг ДЭМБ-ын ТХСК-ийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн төсөл (баримт бичиг FCTC/COP/4/7)-өөс харна уу.

Зөвлөмж

Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн 20, 21, 22 дугаар зүйлийн дагуу олон улсын түвшинд хамтран ажиллаж, тамхинаас гарах хамгийн үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Арга хэмжээ

Тамхинаас гарах дэмжлэг үзүүлэх стратеги, санхүүжүүлэх боломж, эмчилгээний удирдамж, сургалтын стратеги, тамхинд донтолтын эмчилгээний үр дүнг үнэлсэн тайлан, мэдээ зэрэг тамхинаас гарах, донтолтыг эмчлэхтэй холбоотой туршлагаа бусад Оролцогч талуудтай хуваалцана.

Хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ ДЭМБ-ын ТХСК-ийн хэрэгжилтийн тайлан зэрэг олон улсын тайлагналтын механизм, хоёр болон олон талт гэрээ хэлэлцээрийг ашиглана.

Энэхүү удирдамж нь Оролцогч талуудын үйл ажиллагааг үр дүнтэй удирдан чиглүүлж, дэмжлэг үзүүлэх үүргээ биелүүлж чадаж байгаа эсэхийг үе үе тоймлон үнэлж, шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлт оруулна.

(Долоодугаар нэгдсэн хуралдаан, 2010 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр)

-oOo-